



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/146/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2024 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2580 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид
Утас: 9511-2689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Ахлах аудитор Ш.Ганчимэг
Утас: 99377360 Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11-13
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	15-17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	17-18
7. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл.....	19-20
8. Төлбөрийн акт, 01/168, 02/169, 03/170.....	21-25
9. Албан шаардлага, 01/130, 02/131.....	26-27

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 265
танай _____ ны № _____ Т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.АРИУНАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Хутаг-Өндөр сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 116,299.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

БШУС-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/230 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар хуваарилсан 51,548.6 мянган төгрөгийн нөхөн хангалтын санхүүжилтээр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс гэрээний дагуу компьютер, сургалтын тоног төхөөрөмж худалдан авч санхүүгийн тайланд тусгасан байна.

006020582

Бусад асуудлын хэсэг

БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу ЕБС-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллыг олгож эхэлсэн бөгөөд энэ хүрээнд захирал, эрхлэгч нарын ажлын үр дүнгийн урамшууллын асуудал давхар шийдвэрлэгдсэн байна. Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр нийт 47 багшаас 15 багш I-IV түшинд үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>179,314,058.34</u>	<u>293,580,830.06</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	49,870,058.99	116,299,654.88
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	49,870,058.99	116,299,654.88
3121	Төгрөг	49,870,058.99	116,299,654.88
31211	Төрийн сангийн харилцах	49,870,058.99	116,299,654.88
33	АВЛАГА	1,435,343.00	3,328,029.81
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	2,767,029.81
335	Бусад авлага	1,435,343.00	561,000.00
3351	Байгууллагаас авах авлага	1,435,343.00	561,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	128,008,656.35	173,953,145.37
354	Хангамжийн материал	128,008,656.35	173,953,145.37
35410	Бичиг хэргийн материал	6,399,960.00	16,788,650.00
35420	Аж ахуйн материал	57,950,280.45	75,997,340.45
35430	Сэлбэг хэрэгсэл	5,116,200.00	18,594,420.00
35440	Түлш, шатах тослох материал	465,763.99	300,004.01
35450	Барилгын засварын материал	00.00	4,091,475.00
35460	Хүнсний материал	2,212,450.00	2,317,254.00
35470	Бусад хангамжийн материал	55,864,001.91	55,864,001.91
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,854,314,712.96</u>	<u>2,788,882,567.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,795,203,046.28	2,728,454,539.70
392	Биет хөрөнгө	2,795,203,046.28	2,729,828,650.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,750,644,958.41	5,761,944,958.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,513,537,348.33	-3,708,322,379.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	42,500,000.00	42,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,902,777.80	-10,625,000.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	364,332,634.56	528,238,904.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-170,388,512.58	-211,752,195.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	363,867,717.38	414,265,767.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	-84,379,695.23	-128,735,964.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,086,014.83	62,086,014.83
39215	Хуримтлагдсан элэгдэл	-42,003,161.16	-47,754,670.54
39217	Ном	27,983,216.20	27,983,216.20
393	Биет бус хөрөнгө	59,111,666.68	58,996,166.68
39301	Програм хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-337,333.32	-452,833.32
39303	Бусад биет бус хөрөнгө	58,294,000.00	58,294,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,033,628,771.30</u>	<u>3,081,186,125.44</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>561,000.00</u>	<u>4,956,574.99</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	561,000.00	4,956,574.99
413	Өглөг	561,000.00	4,956,574.99
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	561,000.00	2,392,924.99
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	1,864,750.00
4136	Бусад өглөг	00.00	698,900.00

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	698,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,033,067,771.30	3,076,229,550.45
51	Засгийн газрын хувь оролцоо	3,033,067,771.30	3,076,229,550.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	981,093,711.45	981,093,711.45
51101	Өмч: - төрийн	981,093,711.45	981,093,711.45
512	Хуримтлагдсан үр дүн	652,123,170.53	696,562,221.80
51210	Өмнөх үеийн үр дүн	652,123,170.53	652,123,170.53
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	43,161,779.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,399,850,889.32	1,399,850,889.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,033,628,771.30	3,081,186,125.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,387,827,363.44	2,886,830,559.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	254,921,814.00	139,700,059.00
120	Нийтлэг татварын бус орлого	254,921,814.00	139,700,059.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,292,550.00	13,340,589.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,292,550.00	13,340,589.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,132,905,549.44	2,747,130,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,645,834,200.00	2,171,629,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,645,834,200.00	2,171,629,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	487,071,349.44	575,500,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	487,071,349.44	575,500,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,269,280,941.39	2,843,668,779.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,269,280,941.39	2,843,668,779.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,182,507,571.39	2,750,788,542.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,194,776,549.59	1,559,531,546.88
210101	Үндсэн цалин	968,828,100.65	1,557,848,347.78
210102	Нэмэгдэл	172,113,019.78	1,683,199.10
210104	Урамшуулал	53,835,429.16	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,075,940.13	166,838,655.99
210201	Тэтгэврийн даатгал	100,259,394.40	166,838,655.99
210202	Тэтгэмжийн даатгал	10,366,709.87	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,890,716.40	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,856,597.57	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,702,521.89	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	396,752,019.28	497,794,972.66
210301	Гэрэл, цахилгаан	17,054,563.28	22,217,624.60
210302	Түлш, халаалт	373,297,456.00	468,227,348.06
210303	Цэвэр, бохир ус	6,400,000.00	7,350,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,273,450.00	4,743,334.00
210401	Бичиг хэрэг	74,050.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	3,154,400.00	4,743,334.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	45,000.00	00.00
2105	Нормативт зардал	117,424,036.00	148,968,926.00
210502	Хоол, хүнс	117,424,036.00	148,968,926.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,071,160.00	00.00
210604	Урсгал засвар	9,071,160.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,705,200.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,705,200.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	316,429,216.39	372,911,107.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,970,456.00	73,593,580.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,199,650.00	6,852,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	263,259,110.39	292,465,326.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,773,370.00	92,880,237.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,773,370.00	92,507,680.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,773,370.00	92,507,680.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	372,557.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	372,557.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>118,546,422.05</u>	<u>43,161,779.15</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>118,546,422.05</u>	<u>43,161,779.15</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,144,098,099.44</u>	<u>2,760,471,089.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,192,550.00	13,340,589.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,192,550.00	13,340,589.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,192,550.00	13,340,589.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,192,550.00	13,340,589.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,132,905,549.44	2,747,130,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,645,834,200.00	2,171,629,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,645,834,200.00	2,171,629,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	487,071,349.44	575,500,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	487,071,349.44	575,500,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,027,648,840.45</u>	<u>2,594,562,054.11</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,027,648,840.45	2,594,562,054.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,934,290,270.45	2,492,476,296.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,189,727,779.82	1,550,685,792.55
210101	Үндсэн цалин	897,301,955.93	1,060,190,692.14
210102	Нэмэгдэл	232,116,633.33	433,941,141.77
210104	Урамшуулал	60,309,190.56	56,553,958.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,664,475.35	176,185,966.14
210201	Тэтгэврийн даатгал	101,244,634.72	121,210,464.66

210202	Тэтгэмжийн даатгал	11,734,212.87	14,215,954.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,699,420.40	11,291,207.05
210204	Ажилгүйдлийн даатгал	2,271,382.26	2,678,913.26
210205	Эрүүл мэндийн даатгал	22,714,825.10	26,789,426.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	393,495,783.28	498,469,212.68
210301	Гэрэл, цахилгаан	17,054,563.28	22,217,624.60
210302	Түлш, халаалт	370,041,220.00	468,901,588.08
210303	Цэвэр, бохир ус	6,400,000.00	7,350,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	45,000.00	00.00
2105	Нормативт зардал	117,595,046.00	147,058,980.00
210502	Хоол, хүнс	117,595,046.00	147,058,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,697,660.00	37,738,980.00
210604	Урсгал засвар	21,697,660.00	37,738,980.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,528,000.00	15,458,869.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,705,200.00	3,359,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,822,800.00	12,099,569.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,536,526.00	66,878,496.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,568,076.00	49,671,502.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,968,450.00	17,206,994.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,358,570.00	102,085,757.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,358,570.00	101,713,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	93,358,570.00	101,713,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	372,557.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	372,557.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>116,449,258.99</u>	<u>165,909,034.89</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	69,318,500.00	99,244,850.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	69,318,500.00	99,244,850.00
2200	Дотоод эх үүсвэрээр	69,318,500.00	99,244,850.00
222001	Тоног төхөөрөмж	67,318,500.00	99,244,850.00
223001	Бусад хөрөнгө	2,000,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-69,318,500.00</u>	<u>-99,244,850.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	47,130,758.99	66,664,184.89
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,739,300.00	49,870,058.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49,870,058.99	116,451,243.88

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	517,155,783.37	00.00	2,898,100,384.14

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	517,155,783.37	00.00	2,898,100,384.14
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	27,751,185.54	00.00	27,751,185.54
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	652,123,170.53	00.00	3,033,067,771.30
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	652,123,170.53	00.00	3,033,067,771.30
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	652,123,170.53	00.00	3,033,067,771.30
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	43,161,779.15	00.00	43,161,779.15
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	695,284,949.68	00.00	3,076,229,550.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,620,741,749.98	2,557,019,510.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,620,741,749.98	2,557,019,510.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,620,741,749.98	2,455,126,310.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,640,295,700.00	1,532,677,451.87
210101	Үндсэн цалин	1,129,250,800.0	1,042,182,351.46
210102	Нэмэгдэл	450,151,500.00	433,941,141.77
210104	Урамшуулал	60,893,400.00	56,553,958.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,037,400.00	176,185,966.14
210201	Тэтгэврийн даатгал	139,425,600.0	121,415,616.49
210202	Тэтгэмжийн даатгал	16,402,900.0	14,174,923.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,122,400.0	11,166,442.25
210204	Ажилгүйдлийн даатгал	3,280,600.0	3,033,123.14
210205	Эрүүл мэндийн даатгал	32,805,900.0	26,395,860.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	491,119,212.68	498,469,212.68
210301	Гэрэл, цахилгаан	22,217,624.60	22,217,624.60
210302	Түлш, халаалт	468,901,588.08	468,901,588.08
210303	Цэвэр, бохир ус		7,350,000.00
2105	Нормативт зардал	146,183,100.00	142,348,980.00
210502	Хоол, хүнс	146,183,100.00	142,348,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,538,980.0	48,538,980.00
210604	Урсгал засвар	48,538,980.00	48,538,980.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,016,500.00	15,997,269.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,768,800.00	3,897,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,247,700.00	12,099,569.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71550857.30	40908450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,179,357.30	23,701,456.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,371,500.00	17,206,994.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102589300.00	101893200.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	102,589,300.00	101,893,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	102,589,300.0	101,893,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	83,433,250.00	83,433,250.00
2200	Дотоод эх үүсвэрээр	83,433,250.00	83,433,250.00
222001	Тоног төхөөрөмж	83,433,250.00	83,433,250.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,171,049,600.00	2,763,194,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,171,049,600.00	2,171,049,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,171,049,600.00	2,171,049,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	575,500,900.00	575,500,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	575,500,900.00	575,500,900.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,644,400.00	16,644,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,644,400.00	16,644,400.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	49,870,058.99
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	116,299,654.88
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	75.00	75.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	49.00	49.00
620003	Үйлчлэх ажилтан	25.00	25.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хутаг-Өндөр сумын ЕБС нь бүрэн дунд боловсролын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант оны хичээлийн жилд нийт 936 сурагчид, 81 багш ажилтны орон тоогоор заах аргын 4 нэгдэл, захиргаа аж ахуй гэсэн бүтэцтэйгээр ажилласан бөгөөд "Зөв хандлагатай бүтээлч хүүхэд төлөвшүүлнэ. Байгууллагын соёлыг эрхэмлэн хүүхэд бүрийн цогц хөгжлийг дэмжинэ" гэсэн зорилт дэвшүүлж ажиллажээ.

2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг БШУЯ, БШУГ-ын хичээлийн жилийн зорилго зорилтууд, сургуулийн зорилго зорилтуудтай уялдуулан 8 зорилт 71 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу ЕБС-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллыг олгож эхэлсэн бөгөөд энэ хүрээнд захирал, эрхлэгч нарын ажлын үр дүнгийн урамшууллын асуудал давхар шийдвэрлэгдсэн байна. Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр нийт 47 багшаас 15 багш I-IV түшинд үнэлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сургууль нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгал, Татварын багц хуулиуд, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 107,192-р тогтоол, БШУС-ын 2022 оны А/500, А/494, А/430, А/122 дугаар тушаал, Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол, "Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагуудын

жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай" 213 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дугаар тогтоол, БШУС-ын 2023.06.13-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1а/2714 албан бичгээр ЕБС, цэцэрлэгийн нөхөн хангалтыг шийдвэрлэх талаар ирүүлсэн чиглэл зэрэг тайлант онд дээд шатны эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагыг хянан баталж дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг цахимаар хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хутаг-Өндөр сумын ЕБС-ийн 2023 оны санхүүгийн тайланг УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47,557.4 мянган төгрөгөөр буюу 1.56 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	49,870.1	116,451.2	66,581.1
Авлага	1,435.3	3,328.0	1,892.7
Байгууллагаас авах авлага			
Бараа материал	128,008.7	173,953.1	45,944.5
Үндсэн хөрөнгө	6,670,863.5	6,896,467.9	225,604.4

Үндсэн хөрөнгийн элэгдэл	(3,816,548.8)	(4,109,014.1)	(292,465.3)
Нийт хөрөнгө	<u>3,033,628.8</u>	<u>3,081,186.2</u>	<u>47,557.4</u>
Өр төлбөр	561.0	4,956.6	4,395.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,033,067.8	3,076,229.6	43,161.8
Өр төлбөр /богино хугацаат/			
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>3,033,628.8</u>	<u>3,081,186.2</u>	<u>47,557.4</u>

Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 116,451.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ. Үүнээс 549.1 мянган төгрөг нь ахмадын сангийн хөрөнгийн үлдэгдэл байна.

Өмнөх оны авлагын үлдэгдэл 1,892.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 45,944.5 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,896,467.9 мянган төгрөг болж 225,604.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд 225,604.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгө хасагдаагүй байна.

БШУС-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/230 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар хуваарилсан 51,548.6 мянган төгрөгийн нөхөн хангалтын санхүүжилтээс 50,966.9 мянган төгрөгөөр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс гэрээний дагуу компьютер, сургалтын тоног төхөөрөмж худалдан авч санхүүгийн тайланд тусгасан байна. Орон нутгийн урсгал засварын санхүүжилтийн 51,194.9 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн, мөн БШУЯ-аас шилжүүлсэн 126,359.5 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, бүртгэлд тусгасан байна.

Тайлант хугацаанд 292,465.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,076,229.6 мянган төгрөг болж 43,161.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2023 оны төсвийг 1,694,481.5 мянган төгрөгөөр баталсныг тайлант онд 2 удаа өөрчлөлт оруулж, тодотгон оны эцэст 2,238,613.4 мянган төгрөгөөр буюу 544,131.9 мянган төгрөгөөр нэмж баталсан нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,238,613.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 575,500.9 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,122,711.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 115,902.1 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнажээ.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр гаргаж, тайлагнаагүй.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн ахлах аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Д.Туяа нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын ЕБС нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,269,280.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 22,682.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын дүнгээс 70 хувиар тооцон 15,885.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сургууль 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад хуулиар хориглосон асуудлыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд эхний хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, төсвийн төсөл, 3 дугаар улирлын төсөв, гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар гэсэн 5 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар нийт 12,422.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэнээс 4,370.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 8,254.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нягтлан бодох бүртэлтэй холбоотой зөрчилд өгсөн 1 албан шаардлага, 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	1	222,004.9	1	222,004.9	100
Зөвлөмж	3	465,539.3	3	465,539.3	100
Нийт дүн	4	687,544.2	4	687,544.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 69,927.0 мянган төгрөгийн алдааг залруулж, нийт 64,411.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,609.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 59,449.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 353.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Аудитын явцад БШУЯ-аас шилжүүлсэн 69,927.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагагүй зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залруулсан.

5.1 Төлбөрийн акт

1. Дотуур байрны жижүүр Ц.Нямдаваа, Ц.Бурмаа нарт 441.0 төгрөгийн илүү цагийн хөлс үндэслэх баримтгүйгээр тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тотоосон.

2. Аудитын явцад тус сургуулийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийхэд 21 нэр төрлийн 2,564.9 мянган төгрөгийн хүнсний материал дутагдсан нь эд хариуцагч солигдоход дутагдсан байсныг төлүүлээгүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.7-д “*Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан*” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тотоосон.

3. Дотуур байрны хүүхдийн хоолны норматив, норм хэмжээг 2023 оны 2, 3 дугаар сарын дотуур байрны хүүхдийн хоолны өдөрлөгт бичигдсэн хүүхдийн тоо, хүнсний материалын норм, тоо хэмжээг засварлаж, 1,603.1 мянган төгрөгийн материалыг нэмж тооцон зарлагадаж, тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.7-д “*Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан*” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тотоосон.

5.2 Албан шаардлага

1. Орон нутгийн санхүүжилтээр хийгдэх урсгал засварын батлагдсан төсвөөс сургалтын болон амралтын орчин бүрдүүлэх, хичээллэх идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 51,195.0 мянган төгрөгөөр ширээ сандал, хичээлийн угсардаг дугуй ширээ сандал, буйдан, номын тавиур худалдан авч, хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 22 дугаар зүйлийн 22.6.3-д “Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналыг төсвийн ангилалын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангилалын дагуу бэлтгэх”, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан.” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага өглөө.

2. Ур чадварын нэмэгдлийг багш, ажилтнуудад олгохдоо тухайн ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадварын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнээгүй, захирлын тушаалд харгалзах үндэслэл заагаагүй 8,254.3 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалын 4-т “Шалгуур үзүүлэлтийн 3-т заасан нийтлэг шалгуурыг хангасан ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлыг дараах тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ”, 12-т “Ур чадварын нэмэгдлийг тухайн багш, ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадвараас өөр хүчин зүйл (эрүүл мэнд, амьдрал, ахуйн нөхцөл, байдал)-ийг харгалзан олгохыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн тооллогын холбоотой асуудал

Илрүүлэлт:

Захирлын тушаалаар томилогдсон тооллогын комисс жилийн эцсийн тооллогын бүртгэлийг нэгтгэж гаргаагүй, нягтлан бодогч тооцоо бодоогүй, тооллогын үр дүн хангалтгүй байна. Энэ нь ТБОНӨТ-ийн хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон

төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн тооллогыг хууль журмын дагуу зохион байгуулж, үр дүнг хэлэлцэж, шийдвэрлэж байх.

2. Мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Багш, ажилтныг эрүүл мэндийн нэмэлт үзлэг оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулж, хамтран ажиллах тухай гэрээ байгуулсан ч уг гэрээнд үзлэг оношилгооны нэр төрөл, төлбөр, хамрагдах хүний тоо тусгагдаагүй, гэрээг дүгнэлгүйгээр 353.0 мянган төгрөг төлсөн байна.

Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/238, А/340 дүгээр тушаалын 3.1, 3.2, БШУС-ын 2022 оны 07 дугаар сарын 22-ны А/259 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношлогоонд хамруулах заавар”-ын 2.6.1, 2.6.5, 2.8.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид дээрх журам, зааврын дагуу эрүүл мэндийн үзлэг, оношилгоог зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн Тоо	Үүнээс					Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн		Залруулсан		Залруулаагүй			Тоо	Дүн
					Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
БШУЯ-аас шилжүүлсэн хөрөнгийг бүртгэлд тусгуулсан.	1	69,927.0	1	69,927.0		1	69,927.0					
Дүн	-	69,927.0	1	69,927.0	-	1	69,927.0	-	-	-	-	-

